



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 08-ны өдөр

Дугаар А/147

Эрдэнэт

“Дайчлан ажиллуулах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 10.1.3 дахь заалт, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 32 дугаар зүйл, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 20 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг сунгах тухай” А/24 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны “Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай” А/151 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Молор-Эрдэнэ зочид буудлын тусгаарлан ажиглах байранд ажиллах эмч эмнэлгийн мэргэжилтний нэрсийг хавсралтаар баталж, дайчлан ажиллуулсугай.
2. Тусгаарлан ажиглах байранд ажиллах эмч эмнэлгийн мэргэжилтнийг үндсэн ажлаас чөлөөлж, дайчлагдан ажиллах хугацаанд үндсэн цалинг олгохыг салбар байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Дайчлагдан ажиллах эмч эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв /А.Баярхүү/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны
01 дугаар сарын 01-ний өдрийн
147 дугаар тушаалын хавсралт

“Молор-Эрдэнэ” зочид буудлын Тусгаарлан ажиглах байранд ажиллах Эрүүл
мэндийн байгууллагын нэр эмч эмнэлгийн мэргэжилтний овог нэр, мэргэжил

д/д	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Овог, нэр	Гүйцэтгэх үүрэг
1	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	Г.Болд	Их эмч
2	Ачит хувийн хэвшлийн ортой эмнэлэг	В.Цэцэгжаргал	Сувилагч
3	Мөнхийн үйлс хувийн хэвшлийн ортой эмнэлэг	Н.Эрдэнэтуяа	Үйлчлэгч

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны
 05 дугаар сарын 08 өдрийн 1/4 дугаар
 тушаалын хоёрдугаар хавсралт

“Молор-Эрдэнэ” зочид буудлын Тусгаарлан ажиглах байранд ажиллах эмч, мэргэжилтний ажлын цагийн хуваарь

Д/д	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Овог, нэр	Албан тушаал	Тусгаарлах байранд ажиллах өдөр								Тусгаарлалтад байх өдөр							
				05.06	05.07	05.08	05.09	05.10	05.11	05.12	05.13	05.14	05.15	05.16	05.17	05.18	05.19	05.20	
1	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	Г.Болд	Их эмч	8	8	8	8	8	8	8	8	4	4	4	4	4	4	4	
2	Ачит хувийн хэвшлийн ортой эмнэлэг	В.Цэцэг-жаргал	Сувилагч	8	8	8	8	8	8	8	8	4	4	4	4	4	4	4	
3	Мөнхийн үйлс хувийн хэвшлийн ортой эмнэлэг	Н.Эрдэнэ-туяа	Үйлчлэгч	8	8	8	8	8	8	8	8	4	4	4	4	4	4	4	